



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 1/455

Мөрөн сум

Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг нэмэгдүүлэхэд зориулж Мал хамгаалах сангаас 150,000,000 (Нэг зуун тавин сая төгрөг) зарцуулсугай.

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

